



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 19 өдөр

Дугаар А/172

Шивээговь сум

Урьдчилан сэргийлэх арга хэмжээ  
авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.1 дэх хэсэг, Эрүүл мэндийн сайдын 2022 оны “Журам заавар батлах тухай” А/373 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Томуу, томуу төст өвчний тархалт сумын хэмжээнд ихсэж, “Алаг цоог дэгдэлт”-ийн түвшинд шилжин, сумын эрүүл мэндийн төвд хэвтэн эмчлүүлж байгаа хүүхдийн тоо нэмэгдэх хандлагатай байгаа тул хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээг нэмэгдүүлэн, эрүүл мэндийн төвийн амбулаторийн үзлэгийн цагийг 2023 оны 12 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн уртасгасан цагаар ажиллуулсугай.

2. Эмч нарын уртасгасан цагаар ажиллах цагийн хуваарийг хавсралтаар баталсугай.

3. Томуу, томуу төст өвчний дэгдэлтээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимтэй зохион байгуулж, хүний нөөц, эмнэлгийн тусламж үйлчилгээнд шаардагдах эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, лабораторийн хэрэгсэл, оношлуур, урвалж, бодис, хамгаалах хувцас, халдваргүйжүүлэлтийн бодис тээврийн хэрэгслийн бэлэн байдлыг ханган ажиллахыг Эрүүл мэндийн төвийн дарга (П.Ганчимэг)-т, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр иргэдэд томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааг идэвхтэй зохион байгуулж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Мэдээ мэдээлэл, олон нийттэй харилцах ажилтан (Н.Амаржаргал), Эрүүл мэндийн төвийн Нийгмийн эрүүл мэндийн ажилтан (Д.Сансармаа) нарт, байгууллага, иргэдэд мэдээлэл хүргэн, соён гэгээрүүлэх, олон нийтийн газар болон албан байгууллагуудад амны хаалтыг хэрэглүүлж үйлчлүүлэхийг нийт албан байгууллага, аж ахуйн нэгжийн дарга, захирал, эрхлэгч нарт тус тус үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын мэргэжилтэн (Б.Алтансүх)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ч.СУГАРМАА

Сумын Засаг даргын **2023** оны  
**12**-р сарын **19**-ны өдрийн **172** дугаар  
 захирамжийн хавсралт

СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ИХ ЭМЧ НАРЫН УРТАСГАСАН ЦАГААР АЖИЛЛАХ  
 ЦАГИЙН ХУВААРЬ

2023.12.18

№	Эмчийн нэр	Албан тушаал	17	18	19	20	21	22	23	24	25	26	27	28	29	30	31	Ажиллавал	Ажилласан цаг	Илүү цаг
1	П.Ганчимэг	Дарга, их эмч	■				■											72	104	32
2	Х.Сувданцэцэг	Их эмч		■				■										72	104	20
3	Г.Анхбаяр	Их эмч							■				■					72	104	32
4	П.Сансармаа	Их эмч								■								72	88	16

Ажлын өдрүүдэд -Уртасгасан цагаар ажиллах цаг: 08:30-21:30  
 Амралтын өнрүүдэд -уртасгасан цагаар ажиллах цаг: 10:00-16:00